

ХЯТАДЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО

Ч.БАТЦЭЦЭГ*

Санхүүгийн тогтолцоо

Сүүлийн хэдэн арван жилд Хятадын Ардын Банкнаас төв банкуудынхаа бүтэц, хүчин чадлыг үйлдвэр, худалдаа зээл, бизнес хадгаламжийн чиглэлд төвлөрүүлэх үйл ажиллагаа явуулж иржээ. Гэвч Хятадын төв банкны энэхүү үйл ажиллагаа нь үндсэндээ зах зээлийн эдийн засгийн арилжааны хуулийн мөн чанартай зохицож, нийцэхгүй байсан аж. Харин 1979 оноос өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулж эхэлснээр Хятад улс банкны тогтолцоондоо тал бүрийн өөрчлөлт шинэчлэл хийхийн зэрэгцээ гадаадад нээлттэй болж, гадаад харилцаагаа бэхжүүлсэн байна. Ингэснээр санхүүгийн үйлдвэрлэл тогтвортой хөгжих болов. 2003 оны сүүлч гэхэд банкинд оруулсан дотоод, гадаадын мөнгөн гүйлгээний хадгаламжийн тэнцэл (баланс) 22 036.4 тэрбум юань болж, дотоод, гадаад гүйлгээний зээлийн тэнцэл 16 977.1 тэрбум юаньд хүрчээ. Одоо Хятад улс санхүүгийн тогтолцооны зохицуулалтын үндсэн дээр төв банкинд ажиглалт хяналт тогтоосны зэрэгцээ улсын банкиг үндсэнд нь үлдээж, санхүү болон арилжааны санхүү, санхүүгийн төрөл бүрийн байгууллагууд, хоршоонд хуваарилан хоёр талын үйл ажиллагааны нөхцөл байдалд нэмэлт өөрчлөлт оруулан засварлаж, тусгай бодлого явуулж байна.

1984 онд Хятадын Ардын Банкнаас зээл олголт, хадгаламж зэргээр бизнес хийх явдлыг зогсоож, үндэсний банкны тогтолцоонд макро-хяналт, ажиглалт явуулах төв банкны үйл ажиллагаа, хүчин чадлыг албан ёсоор эхлүүлжээ. 1994 онд Хятадын Худалдаа, аж үйлдвэрийн банк, Хятадын Банк, Хятадын Газар тариалангийн банк, Хятадын Бүтээн байгуулалтын банкууд нь арилжааны банкны үйл ажиллагаанд шилжиж,

3 чиглэлээр харилцах бодлого явуулах болж, Хятадын Газар тариалангийн хөгжлийн банк, Улсын хөгжлийн банк, Хятадын экспорт, импортын банк болон байгуулагджээ. 1995 онд Арилжааны банкны хуулийг баталж, арилжааны банкны тогтолцоог бий болгон, бүтэц, зохион байгуулалтын хэлбэрт оруулав; улмаар улсын банкиг өмчийн арилжааны банк болгон өөрчилж, мэргэшүүлэх хууль эрхийн үндэс суурийг сайжруулсан байна. 1996 оноос санхүүгийн зохион байгуулалтын тогтолцоо аажмаар бэхжиж, арилжааны банкууд улсын статусаас орчин үеийн санхүүгийн байгууллагуудын мөнгөн гүйлгээнд шилжиж байна; ингэснээр хувьцаа эзэмшигч жижиг, дунд арилжааны 120 гаруй банк байгуулагдсан буюу шинэчлэгдэн байгуулагдсан; санхүүгийн байгууллагуудын аюулгүй байдал, даатгалыг цаашид стандарчилан хөгжүүлж иржээ. 2003 оны 4 дүгээр сард Хятадын Банкуудыг Зохицуулах Хороо байгуулагдав. Санхүүг зохицуулах тогтолцоогоор Хятадын Банкуудын Зохицуулах Хороо, Хятадын Аюулгүй байдлыг Зохицуулах Хороо болон Хятадын Даатгалыг Зохицуулах Хорооны ажлыг удирдан явуулж, тус бүрийн хариуцлагыг тодорхойлон тогтоожээ.

2004 оны 1 дүгээр сард Улсын Зөвлөлөөс Хятадын Банк болон Хятадын Бүтээн байгуулалтын банкинд хувьцаа эзэмших тогтолцоо руу шилжих туршилт хийж эхэлсэн байна. Орчин үеийн арилжааны банкуудын шаардлагын дагуу нэгтгэлүүдийн менежментийн бүтцийг стандартчилах, дотооддоо хариуцлагын зөв тогтолцоог бий болгох, санхүүгийн тогтолцоог засварлаж, үнэт цаасны гүйлгээг түргэн шуурхай байршуулах, жижиг хөрөнгийн хэрэгцээг эрчимжүүлэх гэх мэт орчин үеийн нэгдүгээр

* Ч.Батцэцэг -ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

зэргийн санхүүгийн газруудыг байгуулах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлсэн юм.

Хятадын үндэсний мөнгөн тэмдэгт болон валютын ханшийн хяналт

Хятадын мөнгөн тэмдэгт юаньд (Renminbi-RMB) зөвхөн Хятадын Ардын Банк дангаараа хууль ёсны хяналт тавьдаг. Юаний ханшийг Хятадын Ардын Банк тогтоон шийдвэрлэх ба Хятад дахь гадаад валютын ханш, солилцоог Улсын байгууллага гүйцэтгэнэ. Хятад дахь гадаад валютын солилцоог зөвхөн Улсын гадаад валютын солилцооны байгууллагын шугамаар хийхийн сацуу үйл ажиллагаа, хүчин чадал, гүйлгээнд хяналт тавьж байна.

1994 онд Хятад дахь гадаад валют хөрвүүлэх тогтолцоог өөрчилж, юаний ханшид зохицуулалт хийж, улмаар банкинд буй валютын ханшийг зохицуулах тогтолцоог шийдвэрлэн, зөвхөн олон улсын банкаар дамжуулан гадаадын валют солих зах зээлийг бий болгосон байна. Үүний үндсэн дээр 1996 онд Хятад улс гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн валют солих бизнесийг банкуудын валют хөрвүүлэх зохицуулалтын дагуул тогтолцоонд багтаан шийдвэрлэсэн болно. 1996 оны 12 дугаар сарын 1-нд Олон улсын валют болон Сангийн тухай Гэрээний 8-р зүйлийг албан ёсоор баталж, юанийг хугацаанаас өмнө хөрвүүлэх гүйлгээ тооцоог хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ Хятад улс АСЕАН-ы орнууд болон Хятад, Япон, Өмнөд Солонгос (10+3)-ын хоорондын хоёр талын гүйлгээ солилцоог идэвхжүүлэн хамтран ажиллах болжээ. 2006 оны сүүлчээр Хятадын гадаад алт, валютын нөөц 1 триллион ам.долларт хүрчээ. Хятадын хувьцаа олон улсын мөнгөн гүйлгээний байгууллага, Сангуудын дотор 11-р байр эзэлж байснаа өсч 8-р байранд оржээ. Санхүүгийн төрөл бүрийн бизнес үйл ажиллагаа тогтвортой өсч, Хятад улс орчин үеийн олон улсын санхүүгийн бизнесийн хэрэгцээт зээл, хөрөнгө оруулалтыг даатгалтай холбосон хөрөнгө оруулалтын аюулгүй байдлын сан зэрэг олон талын шинэ бизнесийн ажлыг цогцоор нь эхлүүлэн ажиллаж байна.

Банкуудын валютын нөөц болон санхүүгийн байгууллагуудын хамтын удирдлага

Өнгөрсөн хорин жилд, Хятадын санхүүгийн байгууллагууд эдийн засгийн онцгой бүс, эрэг хавийн нээлттэй хотууд болон далайгаас алслагдсан төвийн хотуудад төвлөрөн Хятад улс гадаадтай хамтарсан санхүүгийн байгууллагууд үүсэн бий болж, валютын хуримтлалын хэмжээг урамшуулан дэмжиж иржээ. 2002 онд Хятад улсаас хотуудад буй валютын сантай банкуудыг зэрэглэн юаниар харилцан арилжааны гүйлгээ хийх зөвшөөрөл олгон, нээлттэй болгож улмаар сүүлийн хэдэн жилд туршилтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Хятад улсад таван жилийн туршид валютын хуримтлалтай тэдгээр банкуудыг юаний арилжаагаар тооцоо хийхэд нь бүс нутгийн хязгаарлалт тавиагүй байна. Хятадын 13 бүсэд валютын нөөц болон сантай банкууд юаниар харилцан арилжааны бизнесийг эрхэлж, нийт 19 газарт валютын нөөц болон сантай 62 банк үйл ажиллагаа явуулж байна. Хятадад арилжааны бизнесийн байгууллага 191 буйгаас 84 нь юаниар харилцан арилжааны бизнес эрхэлдэг. Мөн Хятадад гадаадын банкны 211 салбар байна.

Валютын нөөц болон сантай банкууд Хятадын бизнесийн хүрээг бодитоор өргөжүүлж байна. 2003 оны 11 дүгээр сард Хятадын Банкуудыг Зохицуулах Хороо Хятадын үйлдвэрийн газруудаас валютын нөөц болон сантай банкуудыг юаниар үйлчлэхийг зөвшөөрч, тус нутаг дэвсгэр дээр юаниар чөлөөтэй, нээлттэй бизнес эрхлэх (урьд өмнө нь валютын нөөц болон сантай банкууд зөвхөн валютын нөөц болон сантай үйлдвэрийн газрууд, Хонгконг, Макао болон Тайваниас ирсэн хувь хүн, гадаадынханд л хотуудад юаниар нээлттэй бизнес үйлчилгээ хийхийг зөвшөөрдөг байв) шинэ бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна. Шинэ бодлого мөн Хятадын банкууд болон санхүүгийн байгууллагууд сайн дурын үндсэн дээр, улмаар арилжааны бааз суурь дээр шинэчлэн засвар хийх, олон улсын стратегийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж байгаа ажээ.

Үүний зэрэгцээ Хятад дахь арилжааны бүх банк гадаад орнуудад салбараа нээж, олон улсад итгэл хүлээсэн бизнес хийж эхлэн,

Хятадын Банк 1 дүгээр зэрэглэлтэйгээр далайн чанадад гарч байна.

1980 онд Хятад улс Дэлхийн Банкинд гишүүнээр элсч, ОУВС-д эргэж оржээ. 1984 оноос Олон улсын дагуул банк (Bank for International Settlements)-тай бизнесийн харилцаа холбоо тогтоож эхэлсэн ба 1985 онд Африкийн хөгжлийн банкид Хятад улс албан ёсоор орж, 1986 онд Азийн хөгжлийн банкны албан ёсны гишүүн болсон байна.

Даатгал

1980 оноос өмнө Хятад улсад зөвхөн ганц л даатгалын компани байв. Өнөөгийн байдлаар Хятадад даатгалын 54 компани, даатгалын зуучлалын 170 компани болон даатгалын 70,000 гаруй агентлагтай болжээ. Мөн валютын сантай даатгалын 37 компанийг Хятад улсад үйл ажиллагаа явуулж бизнес эрхлэхийг дэмжиж байгаа бөгөөд валютын сантай даатгалын 112 компани 19 орон, бүс нутгийг төлөөлсөн албан газар Хятадын 14 хотод байрлаж, Хятадын даатгалын зах зээлд гарахад бэлэн болоод байгаа ажээ.

1981 онд Хятадын Ардын Даатгал компани нь ХХ зууны сүүлч үеийн эцсийн компани бөгөөд анхны үйлдвэрлэлийн компаний хооронд гүүр болж, засгийн газрын байгууллагаас мэргэшсэн компани руу шилжиж, бүх муж, ӨЗО хийгээд орон нутгийн салбарууд орон даяар байгуулагджээ. 1988 онд байгуулагдсан Хятадын Пин Ань (Ping An) группын Даатгалын компани болон Номхон далайн Даатгалын компани нь далайн эрэг хавийн нутагт маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нь үүний гэрч мөн. 1996 онд Хятадын Ардын даатгалын Компани нь засаг захиргааны үйл ажиллагааны тогтолцооноос орчин үеийн зах зээлийн хамтын ажиллагаа руу шилжих томоохон алхам хийсэн юм. 1985 онд Даатгалын хуулийг гаргаж, улмаар 1988 онд Хятадын Даатгалыг Зохицуулах Хороог байгуулж, даатгалын хууль эрхийг үндэслэн тусгайлан удирдаж, зах зээлийн үйл ажиллагааг дэмжих болжээ.

Санхүүгийн орлого

Өнгөрсөн 50 жилийн хугацаанд Хятадын ард түмний аж амьдралын хэв маяг маш ихээр өөрчлөгдөж, ялангуяа сүүлийн хорин жилд дундаж орлого тогтвортой өсч байна.

Өнөөдөр Хятадад хүмүүсийн худалдан авах болон хөрөнгө оруулах чадвар ихээхэн нэмэгдэж, орон сууц, ажлын байр, машин, компьютер, хувьцаа, аялал жуулчлалаар явах бэл мөнгөтэй болжээ. 2003 онд Хятадын нэг хүнд ногдох ДНБ 1,000 ам.доллараас давжээ. 1978 оноос 2003 оны хооронд хөдөөгийн хүн амын нэг хүнд ногдох цэвэр орлого 134-аас 2,622 юань болтлоо өсч, жилийн дундаж өсөлт 7.1%-иар, хотын оршин суугчдын нэг хүнд ногдох цэвэр орлого 343-аас 8,472 болтлоо өсч жилийн дундаж өсөлт 6.8 хувьтай байна.

Хувь хүний орлого өссөнөөр банкинд мөнгөө хадгалуулсан хуримтлал ихээр нэмэгджээ. Өнгөрсөн зууны хоёрдугаар хагасын эхний 30 жилд оршин суугчдын хувийн хадгаламжийн хуримтлалын тэнцэл 1952 онд 860 сая байсан бол өсч 1978 онд 21.06 тэрбум юань болжээ. Өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулж эхэлснээс хойшхи 20 жилд хувийн хадгаламжийн хуримтлал геометрийн өсөлтөөр өссөн. 1979-1986 оны хооронд 8 жилийн дотор хадгаламжийн хуримтлал 10 дахин нэмэгдэж, 223.85 тэрбум байсан бол 1994 онд 2 151.88 тэрбум юаньд хүрчээ. 16 жилийн туршид хадгаламжийн хуримтлалын тэнцэл 100 дахин өсчээ. 2000 оноос хойш 6 жилд хувийн хадгаламжийн хуримтлалын тэнцэл 6,433 24 тэрбум юань буюу 304 дахин өсчээ. 2001 онд 7,376 2 тэрбум юань, 2002 онд 8,691 1 тэрбум юань, 2003 онд 10,361 8 тэрбум юань болж нэмэгджээ. Хувийн валютын хуримтлал, бонд, хувьцаа, үнэт цаас, дотоодын хувьцаа болон бэлэн мөнгөний томоохон нөөц бүгд өсчээ.

Хэрэглээний зардал

Өнөөдөр Хятад улсад хэрэглээний зардлын мөнгийг байр орон сууц, тээвэр, холбоо, цахилгаан сүлжээ, эмнэлэг болон эрүүл мэндийн халамж, соёл, боловсрол, үзвэр үйлчилгээ, амралт, аялал жуулчлал, чөлөөт цагаа өнгөрөөхөд зориулж байна. Урьд нь хотын оршин суугчид зөвхөн зайлшгүй хэрэгцээ болсон хоол хүнс, өмсөх зүүхэд л мөнгөө зарцуулдаг байсан билээ. Нийт хэрэгцээний зардлаас хоол хүнсэнд зарцуулсан хувийг үзэхэд 1978 онд гэхэд хотын оршин суугчид наад зах нь 57,5 хувь,

2002 онд 37.1 хувьтай байсан бол хөдөөгийн хүн ам 67.7%-иас 45.6%-ийг зарцуулжээ.

Өнөөдөр хотын оршин суугчид дээд зэргийн дэлгүүрээс (супермаркет) худалдаа хийж, гадаадын сайн чанарын барааг худалдан авч, гадуур дээд зэргийн зоогийн газарт хооллож байна. Хөдөөгийн хүмүүс тариа будаанд бага мөнгө зарцуулж, өндөг мах иддэг болжээ. Хүн бүр Өрнөдийн болон Хятадын хамгийн сүүлийн үеийн загварын хувцасыг өмсч байна. Байр орон сууц, тээвэр-холбооны тухайд, хүмүүс гэрийнхээ дэргэд туслах аж ахуйтай болж, дээд зэргийн тод өнгөт зурагт, хөргөгч, хөлдөөгч болон бусад эд зүйлс, сүүлийн үеийн угаалгын машин гм худалдаж авч байна. Агааржуулагч, гэрийн үзвэрийн техник хэрэгсэл, ус шүүгч түүнчлэн гэрийн

тавилга, бусад өргөн тархаж буй эд зүйлс видео камер, компьютерт мөнгөө зарцуулж, дундаж өрх хэрэгцээт техник хэрэгслэлээ худалдан авч байна. Хүмүүс олноороо машин худалдан авдаг болжээ. 2003 онд Хятадад машин худалдан авагсад 34,5%-иар өсчээ. 100 машин тутмаас доод тал нь 60 машин хувьд ногдож байгаагаас 80% нь томоохон хотуудад ногдож байна. Байр сууцны туслах хэрэглээний зардал мөн маш ихээр өсөхийн зэрэгцээ нийт үндэстний хувьд тэдгээр зардлын хэмжээ 2003 онд 31,9%-д хүрчээ.

Хятадын ард түмний бодит орлогыг сүүлийн таван жилийн байдлаар гаргахын тулд 2006 оны 3 дугаар сарын 5-нд хуралдсан БХАТИХ-ын арав дахь удаагийн IV чуулганы материалаас авч үзье.

**Хот, хөдөөгийн бодит орлого коэффициентээр
X таван жилийн хугацаанд**

Жил	2001	2002	2003	2004	2005	
Хотын нэг хүнд ногдох бэлэн орлого (юаниар)	6,859.6	7,702.8	8,472.2	9,421.6	10,493	
Бодит өсөлт (%)	8.5	13.4	9.0	7.7	9.6	
Хөдөөгийн нэг хүнд ногдох цэвэр орлого (юаниар)	2,366.4	2,475.6	2,622.2	2,936.4	3,255	
Бодит өсөлт (%)	4.2	4.8	4.3	6.8	6.2	
Engl. коэффициент	Хотын өрх	38.2	37.7	37.1	37.7	36.7
	Хөдөөгийн өрх	47.7	46.2	45.6	47.2	45.5

Ашигласан материал:

1. China Market Economy Construction Seminar (Asia) Oct.12,2005-oct.26, 2005 т.5-8
2. Report on the Implementation of the Central and Local Budgets for 2005 and on the Draft Central and Local Budgets for 2006 (Fourth Session of the Tenth National People's Congress. March 5, 2006)